

**БАТЛАВ: СУРГАЛТ, ЦАХИМ ШИЛЖИЛТИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ Н.ЭРДЭНЭХҮҮ**



**ШУТИС-ийн ОЮУТНЫ ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАХ  
“ЭРДМИЙН ХХИ ЧУУЛГАН”- НЫ УДИРДАМЖ**

**Зорилго:**

Их сургуульд суралцагч оюутнуудын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр чадварыг дээшлүүлэх, бүтээлч сэтгэлгээ, багийн ажиллагааг хөгжүүлэх зорилгоор эрдэм шинжилгээний шилдэг өгүүлэл, шилдэг бүтээлийг шалгаруулж, нийтийн хүртээл болгох.

**Хамрах хүрээ:**

Их сургуулийн бакалаврын түвшинд суралцагч оюутнууд (суралцагч гадаад оюутнууд) оролцоно.

**Хугацаа:**

- I. Оюутны шилдэг эрдэм шинжилгээний өгүүлэл шалгаруулалт: 2023 оны 4 дүгээр сарын 07-нд
- II. Оюутны шилдэг бүтээл шалгаруулалт: 2023 оны 4 дүгээр сарын 28-нд

**I. Оюутны эрдэм шинжилгээний өгүүлэлд тавигдах шаардлага:**

1. Асуудлаа тодорхойлсон байдал, хэрэглээ, ач холбогдол
2. Тухайн асуудлыг шийдвэрлэсэн байдал, онцлог шийдэл
3. Техник технологи, эдийн засгийн судалгаа, тооцоолол
4. Оюутны илтгэх үр чадвар
5. Эрдэм шинжилгээний өгүүлэл нь бичлэгийн стандарт шаардлагыг хангасан байдал.

**Жич:** ШУТИС-ийн эрдэм шинжилгээний өгүүлэл бичих стандартыг баримтална.

Холбооц: [https://www.must.edu.mn/mn/esh\\_oguulel\\_zaaavar/](https://www.must.edu.mn/mn/esh_oguulel_zaaavar/)

**Эрдэм шинжилгээний өгүүллийг шалгаруулах салбар:**

- Салбар 1. Техник, технологи
- Салбар 2. Нийгэм, хүмүүнлэг, дизайн
- Салбар 3. Байгалийн ухаан, экологи
- Салбар 4. Эдийн засаг, менежмент

**Шалгаруулалт, үе шат**

Оюутны шилдэг эрдэм шинжилгээний өгүүллийн шалгаруулалтыг 2 үе шаттайгаар зохион байгуулна.

**1-р шат.** Бүрэлдэхүүн сургуулийн оюутны эрдэм шинжилгээний бага хурлаас салбар бүрт эхний 2 байранд шалгарсан оюутнуудын эрдэм шинжилгээний өгүүллийг хэвлэмэл болон файл хэлбэрээр, албан бичгийн хамт 2023 оны 03 дугаар сарын 20- ны дотор чуулган зохион байгуулах комисс хүлээн авна (файл, ррт-г [studentservice@must.edu.mn](mailto:studentservice@must.edu.mn), хаягт ирүүлнэ). Техник, технологи, Нийгэм, хүмүүнлэг,

дизайн, Байгалийн ухаан, экологийн салбар хуралдааны эхний шатны шалгаруулалтын хэвлэмэл материалыг ШУТИС-ийн хичээлийн I байр 327 тоотод, Эдийн засаг, менежментийн салбар хуралдааны эхний шалгаруулалтын материалыг холбогдох удирдамжийн дагуу 2023 оны 03 сарын 27 ны дотор ШУТИС-ийн БУХС-ийн 204 тоот танхимд хүлээн авна. (файл, ppt-г [nyambayar@must.edu.mn](mailto:nyambayar@must.edu.mn) хаягаар ирүүлнэ).

**2-р шат.** Оюутны эрдэм шинжилгээний шилдэг өгүүлэл шалгаруулах нэгдсэн хурал 2023 оны 04 дүгээр сарын 07-нд Техник, технологийн салбар хуралдаан хичээлийн I байр “Хурлын танхим”-д, Нийгэм, хүмүүнлэг, дизайны салбар ШУТИС-ийн номын сангийн 504 тоот танхимд, Байгалийн ухаан, экологийн салбар хуралдаан ШУТИС-ийн номын сангийн 405 тоот танхимд, Эдийн засаг, менежментийн салбар хуралдаан ШУТИС-ийн БУХС-ийн 205 тоот танхимд тус тус зохион байгуулагдана.

## **II. Оюутны шилдэг бүтээлд тавигдах шаардлага:**

1. Техник, технологийн шийдэл, дэвшилтэт шинэлэг тал
2. Техник технологийн судалгаа, тооцоолол, туршилтын үр дүн
3. Хэрэглээнд нэвтрүүлэх боломж, ач холбогдол
4. Эдийн засгийн үр ашгийн тооцоо (өртөг, зардал, орлого, үр ашиг)
5. Оюутны бүтээлч ажиллагаа (Тухайн бүтээлд багш, оюутны хамтын ажиллагаа, багаар ажилласан байдал, бүтээлийн танилцуулга, бусад)

**Жич:** Оюутан хамтарсан бүтээлээр оролцож болно.

## **Шилдэг бүтээлийг шалгаруулах салбар:**

Салбар 1. Техник, технологи

Салбар 2. Дизайн, байгалийн ухаан, экологи

## **Шалгаруулалт, үе шат:**

Оюутны шилдэг бүтээлийн уралдааныг 2023 оны 04 дүгээр сарын 28-нд зохион байгуулна.

Шилдэг бүтээлийн уралдаанд бүрэлдэхүүн сургуулиудаас салбар бүрт шаардлага хангасан шилдэг 5 хүртэлх бүтээлүүдийг оролцуулж болно.

Шилдэг бүтээлийн уралдаанд оролцох оюутны бүртгэлийг албан бичгээр хүлээн авна. Уралдаанд оролцох бүтээл тус бүрийн танилцуулгыг А-3 хэмжээтэй цаасанд өнгөтөөр хэвлэн, ламинатордож 2023 оны 04 дүгээр сарын 14-ны дотор чуулган зохион байгуулах комисст (ШУТИС-ийн хичээлийн I байр 327 тоотод) ирүүлнэ.

Биет бүтээлийг 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр шилдэг бүтээл шалгаруулах тусгай талбайд байршуулна. (Өмнөх жилүүдэд оролцсон бүтээлүүд сайжруулсан байдлаа тодорхойлсон байх)

Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан цахимаар зохион байгуулах нөхцөлд бүтээлийн танилцуулгыг урьдчилан гаргах тул бүтээлийнхээ танилцуулгыг А-3

хэмжээгээр бэлтгэн 2023 оны 04 дүгээр сарын 14-ны дотор [studentservice@must.edu.mn](mailto:studentservice@must.edu.mn) ирүүлсэн байна.

**Шагнал урамшуулал:**

Эрдэм шинжилгээний шилдэг өгүүлэл, шилдэг бүтээлийг салбар тус бүрт 3 хүртэл байр эзлүүлэн шагнаан урамшуулна.

**I байр Батламж, 800.000 төгрөг**

**II байр Батламж, 500.000 төгрөг**

**III байр Батламж, 300.000 төгрөг**

Оюутны “Эрдмийн XXII чуулган”-д оролцож буй оюутны эрдэм шинжилгээний өгүүлэл, бүтээлийг удирдан ажилласан удирдагч багш нараас шилдэг удирдагч багшийг тус тус шалгаруулан батламж, мөнгөн шагналаар шагнаан урамшуулна.

“Эрдмийн XXII чуулган”-д шалгаран оролцсон оюутнуудын шилдэг эрдэм шинжилгээний өгүүлэл, бүтээлийн танилцуулгыг эмхтгэн хэвлэж хэвлэмэл болон цахим хэлбэрээр нийтийн хүртээл болгоно.

**Анхаарах зүйлс:**

Эхний шатны шалгаруулалт хийгдээгүй болон хугацаа хоцорсон материал хүлээн авахгүй.

**Холбогдох майл хаяг, утас:**

Оюутны хөгжил, соёл, үйлчилгээний  
алба хичээлийн I байр 327 тоот өрөө  
321184, 324590-1035  
[/studentservice@must.edu.mn /](mailto:studentservice@must.edu.mn)

**ЧУУЛГАН ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС**